



ДУНДГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 01 сарын 04 өдөр

Дугаар 09

Мандалговь

Хөрөнгө бүртгэлд авах тухай

Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 дахь заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэхь заалтыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. “Дундгов Ус” орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт өөрийн хөрөнгөөр бэлтгэсэн 90,087,674.00 /Ерэн сая наян долоон мянга зургаан зуун далан дөрвөн төгрөг/-ний үнэ бүхий хөрөнгийг хавсралтын дагуу данс бүртгэлдээ бүртгэж авахыг зөвшөөрсүгэй.
2. Шинээр бэлтгэсэн эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын данс бүртгэлд бүртгэж “Дундговь Ус” орон нутгийн өмчит үйлдвэрийн газар /Д.Ганбаатар/-т даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ц.Мөнгөнцоожид үүрэг болгосугай.

ДАРГА С.СҮХБААТАР



0100016

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2008 оны 01 сарын 04 өдрийн
02 дугаар тогтоолын хавсралт



№	Үндсэн хөрөнгийн нэр	Өртөг /төг/
1	Халуун усны уурын зуухны 1-р тогоо	25,702,387.50
2	Халуун усны уурын зуухны 2-р тогоо	25,702,387.50
3	Халуун усны уурын зуухны 3-р тогоо	16,115,636.00
4	Эх үүсвэрийн харуулын байрны сууц	4,943,462.00
5	Ус түгээр 10-р байрны барилга	5,292,094.00
6	Спорт залны баруун талын дулааны шугам	8,951,707.00
7	Халуун усны газрын дотор шугам	3,380,000.00
8	НИЙТ ДҮН	90,087,674.00